

БАТЛАВ:  
УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРААГИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА Ц.ТӨРХҮҮ

2024 оны ..... дугаар сарын ...-ны өдөр

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Техникийн тодорхойлолтыг хавсаргав.

Багц-1 Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн ландфиллийн талбайд хаалт хийж, нөхөн сэргээлт хийх ажил

Багц-2 Мориндавааны төвлөрсөн хогийн цэгийн ландфилийн талбайд хаалт хийж, нөхөн сэргээлт хийх ажил

### БАГЦ-1, 2 Ландфилийн талбайд хаалт хийх суурийн бэлтгэл ажил

Ажилд тавигдах техникийн шаардлага:

Техникийн нөхөн сэргээлт суурийн бэлтгэл ажил:

1. Хаалт хийх нийт 6 га талбайг 50 см-ын зузаантай хөрсөөр хучиж, нягтаршуулж, тэгшлэх
2. Хаалт хийх талбайг хог хүлээн авах талбайгаас тусгаарлаж 2м өндөртэй нягтаруулсан шороон далан босгох,
3. Тусгаарлалт хийсэн шороон далан дээр 3м өндөртэй төмөр торон хашаа татах ба хашааны багана хоорондын алгасал 3м байна.
4. Хаалт хийх талбайруу 8-10 тонны даацтай усалгааны машин орж гарах замыг хөрсөөр нягтруулж бэлтгэх,
5. Хаалт хийх талбайд хэвтээ, босоо тэнхэлэгийн дагуу 200м тутмын отлолцол дээр метан хий зайлуулах хоолой суурьлуулах ба уг хоолой нь гадаргаас доош 3м, гадаргаас дээш 2м нийт 5м урттай 1м диаметртэй чийг болон галд тэсвэртэй материалаар хийгдэх, агаар сэлгэх боломжтой сээткэн тагтай байна.

Биологийн нөхөн сэргээлтийн ажил:

1. Зүлэгжүүлэлт хийх 2.5 га талбайг 15см зузаантай хар шороо хөрсөөр хучих,
2. Төлөвлөгдсөн зургийн дагуу талбайд олон наст зүлэг тарьж ургуулах,

Ажилд тавигдах ерөнхий шаардлага:

1. Ажилд тавигдах шаардлагын дагуу эскиз зураг бэлтгэж, ажлын төлөвлөгөө үе шатны хуваарь, мэргэшсэн төсөвчнөөр төсөв батлуулж тендерийн баримт бичигт ирүүлнэ. Энэхүү зургийг бэлтгэхдээ ажлын талбайд хэмжилт судалгаа хийсэн байна.

2. Хаалт хийх талбайг хучих хөрсийг хаанаас бэлтгэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл бэлтгэж, ажлын төлөвлөгөө үе шатны хуваарьт тусгана.
3. Хаалт хийх талбайн эргэн тойрны хог хаягдлыг хаалт хийх талбайруу механизмаар түрж орчныг цэвэр болгоно.

ОРЧНЫ БОХИРДОЛ, ХОГ ХАЯГДЛЫН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС